

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд 2 долоо хоног дараалан өслөө.

Газрын тосны ханш өссөнөөр S&P 500 индексийн сагсанд багтдаг эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш өсчээ. Засгийн газрын бондын өгөөж буурснаар хөрөнгө оруулагчид "Netflix" компани болон бусад уламжлалт харилцаа холбооны компаниудын ногдол ашиг өндөртэй хувьцааг сонирхох болж, тус салбарын компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна.

Пүрэв гарагт "Apple" компанийн хувьцааны ханш огцом буурч, мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханшид сөргөөр нөлөөлжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп БНХАУ-ын төрийн тэргүүнтэй уулзан, худалдааны асуудалд томоохон ахиц гарсан талаар мэдээлж, хөрөнгийн зах зээлийн индексүүд өссөн байна.

"Apple" компани борлуулалтын орлогын таамгаа 15 жилд анх удаа буурууллаа. Тус компанийн Гүйцэтгэх захирал Тим Кукийн албан мэдэгдэлд дурдсанаар "Apple" компанийн 2019 оны санхүүгийн жилийн I улирлын борлуулалтын орлого 84 тэрбум ам.доллар байх төлөвтэй байна. Энэхүү мэдээллийн дараа "Apple" компанийн хувьцааны ханш 10 орчим хувиар буурчээ. Шинэ "iPhone"-уудын шинэчлэл хүлээлтэд хараахан хүрээгүй, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсан, "Apple" бугуйн цаг, "iPad Pro", "Airpod" зэрэг бүтээгдэхүүнүүдийн шинэ загварын нийлүүлэлт хязгаарлагдмал байгаа нь нөлөөлсөн гэж Тим Кук хөрөнгө оруулагчдад илгээсэн захидалдаа тайлбарласан байна.

Европ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны хэлэлцээрт ахиц гарсантай холбогдуулан Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

BREXIT-ийн эрсдэлээс сэргийлж Их Британийн үйлдвэрлэгчид бараа материалын нөөцөө нэмж эхэлжээ. Их Британийн үйлдвэрлэлийн салбарын худалдан авагч менежерийн индекс 12 дугаар сард 54.2 нэгж болж өссөн байна. Энэ нь сүүлийн зургаан сарын дээд цэгт тооцогдож байгаа юм. Их Британи Европын Холбооноос хэлэлцээр хийхгүй гарах магадлал өндөр болж байгааг ажиглагчид анхааруулж байгаа аж. Хэрэв Их Британи Европын Холбооноос хэлэлцээргүй гарвал өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өсч, фунт стерлингийн ханш 25 хувиар сулрах эрсдэлтэй байна. Энэ нь компаниудын хувьд бараа материалын нөөцөө нэмэх шалтгаан болжээ.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 2.3%-аар буурчээ.

Дэлхийн эдийн засаг удааширч байгаатай холбогдуулан иенийн ханш чангарах төлөвтэй байна. "Apple" компанийн хувьцааны ханш унаж, АНУ-ын хөрөнгийн зах зээлд ганхаж эхэлсэнтэй холбоотойгоор иенийн ханш ам.долларын эсрэг 4 орчим хувиар чангарчээ.

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	21,713.53	5.17% ▲
Dow Jones	АНУ	23,433.16	1.61% ▲
S&P 500	АНУ	2,531.94	1.86% ▲
Nasdaq	АНУ	6,738.86	2.34% ▲
S&P/TSX	Канад	14,426.52	1.44% ▲
FTSE 100	Их Британи	6,837.42	1.54% ▲
S&P/ASX 200	Австрали	5,619.40	-0.62% ▼
Nikkei 225	Япон	19,561.96	-2.26% ▼
Hang Seng	Хонг Конг	25,626.03	0.48% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	107.15
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	94.86
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	93.72
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.42
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.81
DBM' 2023	USD	7.250%	97.52
TDBM' 2020	USD	9.375%	104.14

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.520	0.00
Libor 3M	2.800	0.00
Libor 6M	2.855	-0.02 ▼
Libor 1YR	2.960	-0.05 ▼
US 2YR Bond	2.496	-0.02 ▼
US 3YR Bond	2.475	-0.02 ▼
US 5YR Bond	2.497	-0.06 ▼
US 10YR Bond	2.668	-0.05 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.01.04	Өөрчлөлт
USD	2,650.55	0.29% ▲
CNY	386.11	0.10% ▲
EUR	3,023.61	-0.17% ▼
RUB	38.76	2.00% ▲
KRW	2.36	-0.42% ▼
JPY	24.58	2.67% ▲
CAD	1,970.82	1.45% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,290.21	0.68% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	15.75	1.81% ▲
Зэс	USD/lb.	264.70	-1.71% ▼
Нүүрс	USD/MT	99.00	-2.56% ▼
WTI газрын тос	USD/bbl.	48.75	5.45% ▲
Brent газрын тос	USD/bbl.	57.9	6.32% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.96	-4.21% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. XI	8.10%
Бодлогын хүү	2018. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. XI	10.20%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	12.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. XI	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	17.30%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. XI	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 39 компанийн 419.2 сая төгрөгийн 917,273 ширхэг хувьцаа, хоёрдогч зах зээлийн багцын арилжаагаар 1 компанийн 84.4 тэрбум төгрөгийн 117,175,348 ширхэг хувьцаа арилжигдав.

“Хай би ойл” /HBO/ компанийн хувьцаа 30.28%-аар буюу хамгийн ихээр өсч 59.8 төгрөгт хүрч хаагдсан бол “Нийслэл өргөө” /NUR/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 7,225 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


1-р сарын 04-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,541.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,713.53 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 5.17%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	84,785.4
Зах зээлийн үнэлгээ	2,541,843.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,713.53	5.17% ▲
MSE I индекс	10,215.63	4.34% ▲
MSE II индекс	8,761.3	0.14% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	117,351,646	84,478,423,306
Говь	207,366	69,803,279
Ард даатгал	79,340	59,777,738
Монгол базальт	154,273	38,734,721
Жинст-Увс	16,501	36,734,235

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хай би ойл	59.80	30.28% ▲
Эрчим Баян Өлгий	529.00	15.00% ▲
Ногоон хөгжил	151.80	15.00% ▲
үндэсний нэгдэл		
Монинжбар	95.00	14.44% ▲
Улсын их дэлгүүр	510.00	12.60% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Нийслэл өргөө	7,225.00	-15.00% ▼
Монголын цахилгаан холбоо	529.00	-8.26% ▼
Хөвсгөл алтан дуулга	151.80	-7.81% ▼
Гермес центр	95.00	-6.67% ▼
Эрдэнэт авто зам	510.00	-4.00% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Голомт Капитал	168,909,537,144
Бумбат-Алтай	128,587,608
Ард секюритиз	118,806,233
Би Ди Сек	118,474,920
Ти Ди Би Капитал	76,097,426

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	640.00	681,076
Таван толгой	7,450.00	392,356
МИК Холдинг	14,750.00	305,462
Говь	340.00	265,238
Сүү	208,82	71,834

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.10-нд олгов
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюты фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	2018.03.06	2018.09.21-нд олгов
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.12.21-нд олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Түмэн шувуут” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах мэдээлэл

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргаж буй 2019 оны анхны компани болох “Түмэн шувуут” ХК нь нийт хувьцааныхаа 25 хувь буюу 50 сая ширхэг хувьцааг нэг бүрийг нь 200 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 10 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр анхдагч зах зээлийн сурталчилгааг эхлүүлээд байна.

Үнэт цаасны худалдан авах захиалгыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан 2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 1 дүгээр сарын 31-ний өдрийн 15:00 цаг хүртэл хүлээн авах бөгөөд худалдан авах захиалгыг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу тогтсон үнийн аргаар авах юм.

Нийтэд санал болгож буй хувьцааны худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтээс давсан тохиолдолд суурь хуваарилалт буюу нийт захиалга өгсөн хүний тоонд тэнцүү хуваан олгох дүнг 3 тэрбум төгрөгөөр тооцож, үлдэх 7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасыг нийт захиалгын мөнгөн дүнтэй харьцуулан хувь тэнцүүлэн хуваарилна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

2018 онд хувьцааны арилжаа түүхэн дээд хэмжээнд хүрлээ

Улиран өнгөрч буй 2018 онд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь үүсгэн байгуулагдсанаас хойш түүхэндээ анх удаа хамгийн олон буюу 6 шинэ үнэт цаасыг бүртгэж арилжсан, анхны давхар бүртгэлийг зах зээлд нэвтрүүлсэн, даатгалын салбарын компаниудын үнэт цаасыг бүртгэсэн зэрэг амжилт бүтээлээр дүүрэн байсан билээ.

Энэхүү амжилтуудыг бататган энэ онд нийт 210 тэрбум төгрөгийн хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа хийсэн нь мөн түүхэн дээд амжилт боллоо. Энэ нь өмнөх түүхэн дээд үзүүлэлт болох 2012 оны үзүүлэлтээс даруй 45 хувиар өссөн дүн юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

2019 онд Азийн ам.доллороор нэрлэсэн бондын арилжаа 300 тэрбум ам.долларт хүрч өсөх төлөвтэй

Азийн ам.доллороор нэрлэсэн бондын эрэлт 2019 онд өсөх төлөвтэй гэж “Aberdeen Standard Investments” компани таамаглаж байна.

Тодруулбал, 2019 онд ам.доллороор нэрлэсэн Азийн бондын арилжаа 250-300 тэрбум ам.доллар хүрч магадгүй байгаа аж. Үүний 33 хувийг нь буюу 105 тэрбум ам.долларыг БНХАУ-ын компаниудын бондууд бүрдүүлэх төлөвтэй байна. 2018 оны IV улиралд БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн компаниудын бондын захиалга тухайн улиралд гаргасан хэмжээнээс 2.6 дахин өндөр байсан нь сүүлийн хоёр жилийн хамгийн тааруу үзүүлэлт болжээ. Хэдий тийм боловч 2019 онд Азийн бондын зах зээл эргэн сэргэх төлөвтэй байгаа юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



МХБ: Бүртгэлтэй компаниудаа чанаржуулахад анхаарна

Дотоодын хөрөнгийн захад хамгийн олон шинэ бүтээгдэхүүн гарсан 2018 онд хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулах шаардлагатай болсныг Монголын Хөрөнгийн бирж мэдээлж байна. Улмаар үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмыг шинэчлэн баталж, Санхүүгийн зохицуулах хороо батламжилснаар тус журмыг 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс мөрдөж эхэллээ. Шинэ компаниудад анхаарахын хажуугаар бүртгэлтэй компаниудаа чанаржуулахад энэ онд илүү их ажлуудыг хийхээр төлөвлөж байгаа юм байна. Тухайлбал, Монголын Хөрөнгийн бирж нийт бүртгэлтэй 99 компанийг үүргийн хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэжээ. Мөн арилжаа нь зогсоод нэгээс дээш жил болсон 29 компанийг бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авах юм. Түүнчлэн Монголын Хөрөнгийн бирж энэ онд олон шинэ бүтээгдэхүүн, ялангуяа давхар бүртгэлтэй үнэт цаасыг зах зээлд гаргах зорилт тавьж байгаа аж.

Мөн гадаадын болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татахад илүү анхаарах юм байна. Үүнтэй холбоотойгоор үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны “Төлбөрийн эсрэг нийлүүлэлт” зарчимд суурилсан T+2 системийг 2019 оны I улиралд багтаан нэвтрүүлэхээр зорьж байгааг Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал онцоллоо.

Харин зохицуулах байгууллагын хувьд Санхүүгийн зохицуулах хороо энэ онд IPO гаргаж байгаа компаниудын чанарыг сайжруулж, хөрөнгө оруулагчдад илүү бодит, үнэн зөв үнэлгээтэй компаниудыг санал болгоход түлхүү анхаарч ажиллана гэдгээ мэдээллээ.

Энэ хүрээнд аудитын, андеррайтерын болон хуулийн байгууллагуудад буюу мэргэжлийн байгууллагуудад тавих хяналтаа нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна. Өөрөөр хэлбэл 2019 онд хөрөнгийн зах зээлийн өсөлт үргэлжлэхтэй зэрэгцээд мэргэжлийн байгууллагууд чанарт илүү анхаарна гэж салбарынхан үзэж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

МХБ: Бүртгэлтэй 54 ХК-ийн 20-иос дээш хувийг жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй 200 гаруй хувьцаат компаниас 54 компанийн 20-иос дээш хувийг жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Өөрөөр хэлбэл нийт бүртгэлтэй компаниудын ойролцоогоор дөрөвний гурав нь төвлөрөл ихтэй байгаа юм.

Санхүүгийн зохицуулах хороо 2017 оноос хойш гарсан зургаан IPO-д 20-иос доошгүй хувиа олон нийтэд санал болгохыг зөвлөсөн байна. Ингэснээр компанийн ил тод нээлттэй байдал, хариуцлага нэмэгдэнэ гэж үзжээ. Тухайлбал, 2018 оны эцсийн байдлаар “Айтүүлс” компанийн 36.8 хувийг 1,136 жижиг хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа юм. Мөн “Монгол базальт” компанийн 30 хувийг 2,350 жижиг хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Харин зах зээлийн үнэлгээ өндөр, томоохон компаниудыг төвлөрөл ихтэй гэж шүүмжилдэг. Хэдий тийм боловч “Мах импекс”, “Монгол шуудан”, “Сүү” зэрэг компаниудын төвлөрөл сүүлийн нэг жилд бага багаар буурч байгааг ҮЦТХТ-ийн судалгаанаас харж болохоор байна. Мөн “Говь” компани хувьцааны төвлөрлөө бууруулж, хөрвөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд 2018 оны 12-р сард нэгж хувьцаагаа 100 хуваасан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

2018 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 10 орчим хувиар өсч, 22 тоннд хүрэв

Монголбанк 2018 онд 22 тонн алт худалдаж авсан гэж мэдээллээ. Энэ нь 2017 оны мөн үеэс 10 орчим хувиар өссөн үзүүлэлт болж байна. Алтны татварыг хөнгөлсөн 2014 оноос хойш Монголбанкинд тушаасан алтны хэмжээ тасралтгүй өссөөр 2017 онд 20 тонн буюу түүхэн дээд хэмжээнд хүрч байжээ.

Харин 2018 оны хувьд түүхэн дээд хэмжээг дахин 10 хувиар ахиулаад байгаа юм. Хэдий тийм боловч УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэж эхэлсэн ч ирц бүрдээгүйгээс болж алтны 2.5 хувийн роялтиг таван жилээр сунгах хуулийн төслийг баталж амжаагүй байна. Ингэснээр алтны роялти 7-9 хувьд хүрэх тооцоотой байгаа гэж Монголбанк мэдээлж байсан юм. Монголбанк алт худалдан авалтаас гадаад валютын албан нөөцийг 750 сая орчим ам.доллараар нэмэгдүүлэх тооцоо хийсэн байна. 2018 оны аравдугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөцийн хэмжээ 3.4 тэрбум ам.доллар буюу сүүлийн зургаан жилийн дээд түвшинд хүрээд байгаа аж. Хэдий тийм боловч гадаад валютын албан нөөцийн хэмжээг дунд хугацаанд 6.5 тэрбум ам.доллар хүргэх зорилтыг 2019 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгажээ. Энэ хүрээнд алт худалдан авалтыг цаашид нэмэгдүүлэх бодлого барина гэж Төв банк мэдэгдсэн юм.

Олон Улсын Валютын Сан зэрэг олон улсын байгууллагууд Монгол Улсын гадаад валютын албан нөөцөд эмзэг байдал оршоор байгааг “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн зургаа дахь шатны үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтдээ онцоллоо. Монголбанк иргэд, аж ахуйн нэгжээс алтыг Лондоны Үнэт металлын биржийн ханш буюу дэлхийн зах зээлийн ханшаар худалдан авч байгаа аж. Алтны спот ханш 1282 орчим ам.долларт хэлбэлзэж байгаа нь сүүлийн зургаан сарын дээд түвшин болж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



2018 онд Шивээхүрэн-Сэхэ боомтоор экспортолсон нүүрсний хэмжээ 1.4 сая тонноор нэмэгдэв

2018 онд нийт 32 компани нүүрсний экспорт хийхээр уулын ажлын төлөвлөгөө боловсруулснаас 21 нь экспорт хийсэн байна. Өмнөговь аймагт хамгийн олон буюу 17 нүүрсний талбай, Дорноговь аймагт 13, Сүхбаатар аймагт 11 талбайгаас нүүрс экспортолсон талаар Ашигт малтмал, Газрын тосны газраас мэдээллээ.

Нүүрсний гол боомтуудыг харвал Гашуунсухайт-Ганцмод боомтоор Тавантолгойн бүлэг ордод олборлолт хийж байгаа “Эрдэнэс Тавантолгой”, “Energy Resource”, орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК нийт 18.2 сая тонн нүүрс экспортолсон байна. Энэ нь өмнөх жилийнхээс нэг сая тонноор нэмэгджээ. Харин Шивээхүрэн-Сэхэ боомтоор Нарийнсухайтын бүлэг ордод олборлолт хийж байгаа “SouthGobi Sands”, МАК, “Өсөх зоос”, “Шинхуа МАК”, “Жавхлант орд” ХХК-иас гадна “Terra Energy” компани нийт 14.1 сая тонн нүүрс экспортолсон байна. Энэ нь 2017 оныхтой харьцуулахад 1.4 сая тонноор нэмэгдсэн талаар тус боомтын гаалийн газар мэдээллээ.

Үүнээс гадна Булган-Такашикэн боомтоор Хөшөөтийн уурхайгаас “Mongolia Energy Corporation” нүүрс экспортолж байгаа бөгөөд 2018 онд 700 мянга орчим тонн нүүрс экспортолсон гэж тус компани мэдэгдсэн юм. Түүнчлэн Замын-Үүд-Эрээний боомтоор төмөр замаар нэг сая 800 мянган тонн нүүрс тээвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос 450 мянган тонноор нэмэгдсэн талаар “Улаанбаатар төмөр зам” компани мэдээллээ. Эрдэнэт, Олон овоо, Чойр, Айраг, Зүүнбаян өртөөнөөс нүүрс нийлүүлж байна. Энэ дундаас зөвхөн Олон овоо өртөө орчмын таван уурхайгаас нэг сая 400 мянган тонн нүүрс экспортолжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



Уул уурхайн салбарын боловсруулах үйлдвэрийн төслүүд ямар шатандаа байна вэ

Нэг тэрбум ам.долларын санхүүжилттэй газрын тос боловсруулах үйлдвэрийг 2023 оны I улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээлээд байна.

Одоогоор төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугам зэрэг дэд бүтцийн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байгаа ажээ. Барилгын ажлыг 12 дугаар сарын эцсээр зогсоож, гуравдугаар сард эхлэх бөгөөд улмаар ирэх оны III улиралд дуусгахаар зорьж байна. Газрын тосны үйлдвэр ашиглалтад орсноор үйлдвэрээс гарах нэг литр бүтээгдэхүүний дундаж өртөг 0.348 ам.доллар /34 цент/ буюу 850 орчим төгрөг байна гэж тооцож байгаа аж.

Үүнээс гадна зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд суманд барихаар төлөвлөж байна. Хамгийн сүүлд 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар Ханбогд суманд 466 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргасан юм. Өмнө нь дурдаж байсанчлан энэ үйлдвэрт жилд 257 мянган тонн цэвэр зэс үйлдвэрлэж, 1.9-2 тэрбум долларын борлуулалт хийх боломжтой гэж өмнө нь албаны эх сурвалжууд мэдээлж байв.

Харин алт цэвэршүүлэх үйлдвэрийн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах бэлтгэл ажлыг хангахаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам ажиллаж байна. Түүнчлэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани болох “Мон атом” компани болон “Орано” компанийн хамтарсан “Бадрах энерги” компанийн уран олборлох туршилтын үйлдвэр бэлэн болсон талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээлсэн юм. Дээрх компани Дорноговь аймгийн Зүүнбаян багийн нутагт орших ураны Зөөвч-Овоо, Дулаан-Уул ордуудын төслийг хариуцаж байгаа ажээ. Харин хувийн хэвшлээс Нарийнсухайтын бүлэг ордод олборлолт хийж байгаа “Өсөх зоос” ХХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр энэ оны долоодугаар сард ашиглалтад орох товтой байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

2018 оны турш сар бүр 85-220 сая ам.долларын ГШХО Монгол Улсад орж иржээ

2018 оны 11-р сарын байдлаар Монгол Улсад 1.5 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 306 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

2018 оны турш сар бүр 85-220 орчим сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт Монгол Улсад орж ирснийг төлбөрийн тэнцлийн тайлангаас харж болохоор байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг “Оюу Толгой” төслийн хоёр дахь шатны бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт эзэлж байна. 2019 онд онд “Оюу Толгой” төсөлд 1.3 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалт орж ирэх тооцоог Сангийн яам хийжээ. 2016 онд -400 сая ам.доллар хүрч буураад байсан гадаадын шууд хөрөнгө оруулалт сүүлийн хоёр жилд нэг тэрбум ам.доллар даваад байгаа юм. Харин урт хугацаанд нь харвал 2011, 2012 онд буюу гадаадын шууд хөрөнгө оруулалтын оргил үед 4.5 тэрбум ам.доллар хүрч байжээ.

2013 онд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталснаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын орчин сайжирсан гэж эдийн засагч Ж.Дэлгэрсайхан үзэж байна. Хэдий тийм боловч улс төр, бодлогын тогтворгүй байдал хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж байгаа гэж харж байгаа юм. Мөн дэлхийн эдийн засагт эрсдэл үүссэнтэй холбоотой хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах нь сорилт болно гэж зарим шинжээчид анхааруулж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Гадаад валютын албан нөөц 2018/XI сард 3.47 тэрбум ам.доллар хүрч өсжээ

Гадаад валютын албан нөөцийн хэмжээ 2018 оны 11 дүгээр сарын байдлаар гурван тэрбум 477 сая ам.доллар хүрсэн гэж Төв банк мэдээллээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 52 орчим хувиар өссөн үзүүлэлт болж байна.

Монголбанк гадаад валютын албан нөөцийн хэмжээ зургаан жилийн дээд түвшинд хүрсэн гэж онцолж байгаа юм. 11 дүгээр сард Монголбанк 248.3 сая ам.долларыг валютын захад нийлүүлжээ. 2018 онд нийт нэг тэрбум 262 сая ам.долларын интервенц хийгээд байна. 2018 онд орж ирсэн орох урсгалыг дурдвал Олон Улсын Валютын Сангийн тогтмол санхүүжилтээс гадна Хөгжлийн банк аравдугаар сард олон улсын зах зээлээс 500 сая ам.долларын бонд босгосон юм. Энэ нь гадаад валютын албан нөөцийн хэмжээ өсөхөд эергээр нөлөөлсөн байна.

Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2018 оны эхний 10 сарын байдлаар 1.4 тэрбум ам.долларт хүрчээ. Хэдий тийм боловч 2018 онд Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрийн хүрээнд донор орнуудын амласан 850 сая ам.долларын санхүүжилтээс 300 сая ам.доллар орж ирсэн юм. Тиймээс 2019 онд Олон Улсын Валютын Сангийн санхүүжилтээс гадна Дэлхийн банк, Япон улсын Засгийн газрын санхүүжилтүүд орж ирэх хүлээлттэй байна.

Монголбанк 2019 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэлдээ Гадаад валютын албан нөөцийг дунд хугацаанд 6.5 тэрбум ам.долларт хүргэх шаардлагатай гэж онцолж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



Шинжээчдийн анхааруулж байсанчлан урсгал дансны алдагдал 1.5 тэрбум ам.доллар болж өслөө

2018 оны 11 дүгээр сард төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх сараас 66.5 сая ам.доллараар нэмэгдэж, 117.7 сая ам.доллар хүрсэн байна. Азийн хөгжлийн банк, Олон Улсын Валютын Сангийн таамаглаж байсанчлан урсгал дансны алдагдал тайлант хугацаанд өсч, 1.5 тэрбум ам.доллар давжээ. Гарах урсгалыг харвал 2018 оны I-XI сард тээврийн үйлчилгээнд 733 сая ам.доллар зарцуулсан байна. Мөн аялал, жуулчлалд 644 сая ам.доллар, бизнесийн үйлчилгээнд 931 сая ам.доллар зарцуулжээ. Оны эхний 11 сард Монгол Улс 33.8 сая тонн нүүрс экспортолсон бөгөөд энэ нь 2017 оны жилийн эцсээс давсан дүн болж байна. Нүүрсний тээвэр экспортын орлогыг нэмэгдүүлж байгаа ч тээврийн үйлчилгээний зардал өсөж гарах урсгал ч мөн адил нэмэгдсэн дүр зурагтай байгаа юм.

Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 673 сая ам.доллараар буурч, 1.1 тэрбум ам.долларын ашигтай байна. Худалдааны тэнцэл буурахад импортын өсөлт голлон нөлөөлсөн гэж Төв банк үзжээ. Тухайлбал, импорт 11 дүгээр сард 38 хувиар өссөн байна. Он гарснаас хойш импортын өсөлт 40 орчим хувийн өсөлтөө хадгалж байгаа юм. Хэдий тийм боловч импортын өсөлтийн дийлэнх хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн орц эзэлж байна.

Харин тайлант хугацаанд нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 28 хувиар, өмнөх сараас дөрвөн хувиар өсөж, тонн тутамд 792 ам.долларт хүрчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.